



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 5 сарын 20 өдөр

Дугаар 240

Улаанбаатар хот

┌ Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 он 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйлийн 20.8 дугаар хэсэгт 20.8.3, 20.8¹, 20.9¹, 21 дүгээр зүйлийн 21.1 дүгээр хэсэгт 21.1.6¹ гэсэн дараах утга агуулга бүхий заалт, хэсгийг нэмсүгэй:

1/ “20.8.3. Компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, эсрэг саналтай байсан болон өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардсан хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг зуучлуулан тараалгахаар үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай байгуулсан гэрээ.”

2/ “20.8¹. Хороо бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой нэмэлт баримт бичгийг шаардаж болох бөгөөд энэхүү шаардлага хүргүүлсэнээс хойш ажлын тав хоногт уг баримт бичгийг ирүүлээгүй бол Хорооны улсын байцаагч үнэт цаасны арилжааг сэргээнэ.”

3/ “20.9¹. Үнэт цаасны бүртгэлийн журмын 20 дугаар зүйлийн 20.8.3-д заасан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагийн харилцах дансанд байршуулна.”

4/ “21.1.6¹. Үнэт цаасны бүртгэлээс хасуулах хүсэлт гаргасан;”

2. Мөн журмын 20 дугаар зүйлийн 20.7, 21 дүгээр зүйлийн 21.1, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ “20.7. Компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хуралд тухайн асуудлаар эсрэг саналтай байсан болон хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай мэдэгдлийг хурлын зар мэдээ хүргэх журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдээллэх ажлыг зохион байгуулна.”

2/ “21.1. Хорооны улсын байцаагч нь зах зээлийн хэвийн үйл ажиллагаа эрсдэлд орсон буюу орж болзошгүй, эсхүл хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дараах үндэслэлээр үнэт цаасны арилжааг зогсооно.”

000000

3/ “24.1. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа Хорооны бүртгэлээс хасуулах буюу арилжааг зогсоох тухай дараах мэдээлэл бүхий хүсэлтийг Хороонд гаргах ба арилжааг хүсэлт гаргасан өдрөөр тасалбар болгон зогсооно:”

3. Монгол улсын Өрийн удирдлагын тухай хуулиар засгийн газар, аймаг, нийслэлийн засаг даргаас үнэт цаас гаргах, арилжаалахтай холбогдсон харилцааг зохицуулах болсон тул “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар зүйлийн 8.3, 8.4, 8.5, 8.6, 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх хэсгүүдийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА